



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 24 өдөр

Дугаар Б/65

Жавхлант

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Засгийн газрын 2022 оны 02-р тогтоол /Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам/-ын 3.6.4 дэх заалт, сумын ИТХ-ын 2024 оны 12 сарын 30-ны өдрийн 3 дугаар хуралдааны А/19 дугаар тогтоолын 05 дугаар хавсралт /Байгалийн нөөц ашигласан орлогоос санхүүжүүлэх төсвийн жагсаалтын 5 дахь хэсэг/ тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Идлэг шонхор болон шувуудыг 15кв цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугаманд богино холболт үүсч холбогдохоос сэргийлж бүрээс хийлгэх “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу нийт 10.000 000 (арван сая) төгрөгийг зарцуулсугай.

2.Зарцуулах төсвийг Байгалийн нөөц ашигласан орлогоос 2025 онд санхүүжүүлэх төсвөөс гаргахыг Нягтлан бодогч (Э.Уранбайгаль)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Шаравгаваа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.БАТЧУЛУУН